



# ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ БАЙДЛААР



## Агуулга

- |   |       |
|---|-------|
| 1. Онцлох үйл явдал   | 3-5   |
| 2. Санхүүгийн үзүүлэлтүүд   | 6-12  |
| 3. Монголбанкнаас тогтоосон зохистой<br>харьцааны шалгуур үзүүлэлтүүд | 13-14 |
| 4. Компанийн засаглал   | 15-17 |

# Онцлох үйл явдал

## 236 сая ам.долларын гэрээ байгуулав



Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжихээр Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO), Азийн Хөгжлийн Банк (ADB), Германы Хөрөнгө Оруулалт, Хөгжлийн Корпораци (DEG), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD), Франц Улсын Хөгжлийн Санхүүгийн Байгууллага (Proparco), rA, Finnfund, TripleJump, DWM, Symbiotics зэрэг байгууллагуудтай нийт **236.0 сая ам.долларын** гэрээ байгуулж үүнээс 176.0 сая ам.долларыг татан төвлөрүүлэв.

## Шилдэг төслөөр шалгарлаа



ХасБанкны Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн хөтөлбөр Даян дэлхийн уур амьсгалын түншлэлийн сан (GCPF)-ийн 2024 оны шилдэг төслөөр шалгарч, 10-р сарын 18-ны өдөр Швейцарын Цюрих хотноо болсон ёслолын үеэр шагналыг гардаж авлаа.

## Зээлжих зэрэглэл



Олон улсын үнэлгээний Moody's болон Fitch Ratings агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцээд ХасБанкны зээлжих зэрэглэлийг мөн "B2 тогтвортой" болон "B+ тогтвортой" болгон тус тус нэг шат ахиулан сайжрууллаа.

## Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр



ТУЗ-ийн шийдвэр болон зохицуулагч байгууллагуудаас өгсөн зөвшөөрлийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ.

# Онцлох үйл явдал

| Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ



**#Одоо Асуудалгүй 😊**

Харилцагчид харилцах дансныхаа мөнгөн хөрөнгийн хэмжээг үл харгалзан тодорхой дүн хүртэл зарлага гаргах эрх олгох үйлчилгээг анх удаа нэвтрүүллээ.

**AMAR**

Бага дүнтэй гэнэтийн мөнгөний хэрэгцээг богино хугацаанд хялбараар шийдэх АМАР зээлийг шинэчлэн нэвтрүүлэв.

**Уртаар**

Сторпэй ХХК-тай хамтран "Уртаар" онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ. Ингэснээр хэрэглэгчид хүссэн бүтээгдэхүүнээ урт хугацаатай зээлээр худалдан авахдаа 100% онлайнаар хурдан шуурхай шийдүүлэх боломжийг нээсэн.

**Зорилготой хадгаламж**

Зорилгодоо нийцүүлэн хугацаагаа уян хатан тогтоож болох хадгаламжийн шинэ бүтээгдэхүүн дижитал суваг дээр бий болголоо.

**Slice**

Хэрэглэгч хүссэн бүтээгдэхүүнээ хүүгүй, шимтгэлгүй 4 хуваан худалдан авах боломж бүхий Slice онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ.

**ПОС-н орлого барьцаалсан дижитал зээл**


ПОС-н орлого барьцаалсан зээлийг 100% дижитал хувилбараар сайжруулан нэвтрүүллээ.

**Ханбогд хөгжлийн хурдасгуур Оюу толгой сангийн түншлэл**

Өмнөговь аймгийн Ханбогд суманд бизнесийн үйл ажиллагаа явуулж буй болон шинээр бизнес эрхлэх гэж буй иргэн, хуулийн этгээдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий бизнесийн зээл олгох боломжтой боллоо.

**Хөтөлбөрийн зээл**

ХХААХҮЯам, Батлан даалтын сантай хамтарсан Хоршооны гишүүн малчны зээл, СПАЖЗЯамтай хамтарсан аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүллээ.



# Онцлох үйл явдал

| Картын шинэ бүтээгдэхүүн



## Тэмүүлэл карт

7-18 насныханд зориулсан Тэмүүлэл карт нийтийн тээвэрт хүүхдийн тарифаар зорчих, дижитал банкаар дансаа удирдах болон бусад хугацаат урамшуулал буцаан олголтод хамрагдах боломжтойгоор шинэчлэгдлээ.



## Хасын Хүлэгүүд карт

Сагсан бөмбөгийн Үндэсний дээд лигийн 8 удаагийн аварга Хасын Хүлэгүүд багийн фенүүд, сагсан бөмбөг сонирхогч хэн бүхэнд зориулан Хүлэгүүд картыг цөөн тоогоор гаргалаа.



## Олимп карт

Парис 2024 зуны олимпт зориулсан картыг цөөн тоогоор гаргалаа.




## Future карт

Оюутан залууст зориулан эх дэлхийдээ эзлтэй дахин боловсруулсан пластик материалыаар хийгдсэн картыг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 80 гаруй их дээд сургуулийн 12 мянга гаруй оюутнуудын сонголт боллоо.



## Түншлэгч байгууллагуудын карт

Монголын Алт Корпорацийн 30 жилийн оид, УБТЗ-ын 75 жилийн оид, Сүү ХК-ийн бэлтгэн нийлүүлэгч малчид, фермерүүдэд зориулсан төлбөрийн картуудыг тус тус гаргалаа.



# Санхүүгийн үр дүн

2024 оны жилийн эцэс

| Цэвэр ашиг    | ROE   | ХАС (Хувьцааны ханш) | EPS  | 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа |
|---------------|-------|----------------------|------|---|--|
| ₮170.9 тэрбум | 25.6% | ₮826.0               | ₮162 | 19.2% >12.5%                                      | 38.4% >25.0%                             |

## Ашигт ажиллагаа

- 2024 оны жилийн эцэст ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 170.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 20.3 хувь өслөө. Тайлант хугацаанд Банкны зээлийн багц өссөн болон активын чанарын сайжирсан нь ашгийн хэмжээ нэмэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.
- 2024 оны 12 сарын 31-ний байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 25.6 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 162 төгрөг байна.
- 2024 онд нийт 45.5 тэрбум төгрөгийн буюу нэгж хувьцаанд 43.25 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараалаа.

## Баланс

- Нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц өмнөх оноос 34.5 хувиар өсөж 3,697 тэрбум төгрөгт хүрлээ.
- Иргэдийн банкны зээлийн багц 34.6 хувиар өсөж 2,587 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн өсөлт нөлөөлжээ.
- Бэлтгэн нийлүүлэгчидтэй хийсэн хамтын ажиллагаа өргөжсөн, автомашины зээлийн төвүүдийн зэргээс хамааран санхүүгийн түрээсийн багц 36.1 хувиар өсөж 467 тэрбум төгрөгт хүрлээ.
- Байгууллагын банкны зээлийн багц 32.7 хувиар өсөж 643 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ 19.1 хувиар өсөж 3,425 тэрбум төгрөгт, гадаад эх үүсвэрийн хэмжээ 35.8 хувиар өсөж 449 сая ам.долларт тус тус хүрлээ.

## Харьцаа үзүүлэлт


- 2024 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод шаардлагыг 6.7 хувиар давуулан биелүүлж 19.2 хувьд хүрлээ.
- 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 38.4%-ийг бэлэн мөнгө болон түргэн борлогдох активт байршуулан удирдаж байна.
- Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ буурч 2.0 хувь боллоо.

# Санхүүгийн үзүүлэлтийн тренд

| 2024 оны жилийн эцэс

## Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



## Нийт актив

Тэрбум төгрөг




## Зээлийн багц

Тэрбум төгрөг



## ROE

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



## 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



# Зээлийн үйл ажиллагаа

| 2024 оны жилийн эцэс

## Нийт зээлийн тоо

**188 мянга**  14.5% YoY

## Онлайн зээлийн тоо

**112 мянга**  17.5% YoY

## Зээлийн хүүгийн орлого

**₮561 тэрбум**  40.3% YoY

### Зээлийн багц

Тэрбум төгрөг

Чанаргүй  
зээлийн хувь



### Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөг

■ 2023 ■ 2024



- 2024 онд зээлийн багцын өсөлтөд бичил жижиг бизнесийн зээл, хэрэглээний зээл болон санхүүгийн түрээсийн багцын өсөлт голчлон нөлөөлжээ.

- Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол буурч 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2.0 хувьд хүрсэн нь нийт зээлийн багцын өсөлтөөс гадна чанаргүй зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй байсныг харуулж байна.

# Дотоод эх үүсвэр

| 2024 оны жилийн эцэс

## Нийт дансны тоо

**1.4 сая**  8.6% YoY

## Хадгаламжийн дансны тоо


**531 мянга**  5.1% YoY

## Харилцагчдад олгосон хүү

**₮219 тэрбум**  35.0% YoY

### Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



### Харилцах, хадгаламж бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- ХасБанк нь харилцагчдын онцлог хэрэгцээ бүрд тохирсон харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог бөгөөд өсөлтөө тогтвортой хадгалж ирсэн.

- Хадгаламж эзэмшигч, харилцагчдад чиглэсэн урамшуулалт хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээр 2024 онд нийт харилцах болон хадгаламж 19.1% хувиар өссөн байна.

# Гадаад эх үүсвэр

| 2024 оны жилийн эцэс

2024 онд FMO, ADB, DEG, EBRD, Proparco, rA, Finnfund, TripleJump, DWM, Symbiotics гэсэн байгууллагуудтай нийт 236.0 сая ам.долларын гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 176.0 сая ам.долларыг татан төвлөрүүлээд байна. Үлдэгдэл 60.0 сая ам.долларыг 2025 онд татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

## Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



## Шинээр байгуулсан гэрээ болон татан төвлөрүүлсэн эх үүсвэр

|  |   |  |
|--|---|--|
| <b>FMO</b><br>Entrepreneurial Development Bank<br>\$50,000,000   | <b>ADB</b><br>ASIAN DEVELOPMENT BANK<br>\$50,000,000  | <b>KFW DEG</b><br>\$30,000,000   |
|  European Bank for Reconstruction and Development<br>\$25,000,000 |  PROPARCO GROUPE AFD<br>\$25,000,000 |  responsAbility<br>\$20,750,000 |
|  finnFund<br>\$10,000,000   |  Triple Jump<br>\$10,000,000         |  dwm<br>\$9,250,000             |
|  symbiotics<br>\$6,000,000  |   |  |

# Зээлжих зэрэглэл

| 2024 оны жилийн эцэс

ХасБанк 2008 оноос дэлхийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг тасралтгүй хийлгэж байна. 2024 онд тус 2 үнэлгээний агентлагаас Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцээд ХасБанкны зээлжих зэрэглэлийг “B2 тогтвортой” болон “B+ тогтвортой” болгож нэг шатлалаар тус тус ахиуллаа.

## Зээлжих зэрэглэл

Fitch Ratings

Moody's

|      | Fitch Ratings    | Moody's          |
|------|------------------|------------------|
| 2024 | B+<br>тогтвортой | B2<br>тогтвортой |
| 2023 | B<br>тогтвортой  | B3<br>тогтвортой |

Тус үнэлгээний байгууллагууд ХасБанкны үнэлгээг нэг шат ахиулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзжээ.\*

- Монгол Улсын эдийн засгийн орчны цаашдын хандлага: Монгол улсын эдийн засаг дунд хугацаанд тогтвортой өсөх хүлээлттэй байгаа бөгөөд энэ нь банкны салбарт эерэгцээр нөлөөлөхөөр байна.
- Өсөлт: ХасБанк нь зээлийн багцын өндөр өсөлтийг хангахын зэрэгцээ активын чанар болоод өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувьд салбарын дунджаас илүү байна.
- Активын чанар: 2024 оны хагас жилийн байдлаар чанаргүй зээлийн хувь 2.2 хувь байсан нь салбарын дундаж болох 5.9 хувиас бага байна.
- Ашигт ажиллагаа: 2023 оны эцэст цэвэр ашиг 34 хувийн өсөлттэй гарсан бөгөөд цаашид ч мөн адил зээлийн багцын өсөлтөөс хамааран ашигт ажиллагаа сайжрах төлөвтэй байна.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: Банкны ашигт ажиллагаа хэвийн үргэлжлэх төлөвтэй байгаа нь тус банкны өөрийн хөрөнгийн хүрээлцээ тогтвортой өндөр байх үндэс болж байна.
- Хөрвөх чадвар: Гадаадын санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 57 хувиар өссөн бөгөөд энэ нь нийт эх үүсвэрийн 27 хувийг бүрдүүлжээ.

\* Эх сурвалж: Fitch Ratings-ийн үнэлгээний тайлан

# Хувьцааны мэдээлэл

| 2024 оны жилийн эцэс


2024 оны 12 дугаар сарын 31-ний буюу оны сүүлийн арилжааны өдөр ХасБанкны хувьцааны хаалтын ханш 826.0 төгрөгт хүрч өмнөх оны хаалтын ханшаас 31.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд 2023 оны сүүлийн хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 25.25 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, 2024 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр тус тус хувьцаа эзэмшигчдээ тараалаа. 2024 онд тараасан нийт ногдол ашгийн хэмжээ 45.5 тэрбум төгрөг буюу ногдол ашгийн өгөөж 6.9\* хувьтай байна.

## ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



## Ногдол ашиг




\* Ногдол ашгийн өгөөжийг тухайн онд тараасан нэгж хувьцааны ногдол ашгийг 2023 оны хаалтын ханшинд харьцуулж тооцв.

# Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

| 2024 оны жилийн эцэс

## 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

**19.2%** Байвал зохих доод хэмжээ 12.5%




## Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

**38.4%** Байвал зохих доод хэмжээ 25.0%

## Түргэн борлогдох актив

Нийт 2,034.2 тэрбум төгрөг



# Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

|  | 2022  | 2023  | 2024  |
|--|-------|-------|-------|
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа<br>(нэгж валютаар) +/-15% | 6.2%  | -1.3% | -1.7% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа<br>(нийт валютаар) +/-30% | 6.9%  | -1.4% | -2.0% |
| Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%                       | 66.6% | 38.6% | 41.7% |
| Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%  | 1.7%  | 1.3%  | 1.2%  |
| Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%   | 7.7%  | 7.8%  | 7.9%  |

|  | 2022 | 2023 | 2024 |
|--|------|------|------|
|--|------|------|------|

Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):

|                                  |      |      |      |
|----------------------------------|------|------|------|
| Банкны хувьцаа эзэмшигчид        | 0.0% | 0.8% | 2.4% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.1% | 0.1% | 0.1% |
| Банкны бусад холбогдох этгээд    | 1.6% | 3.2% | 0.0% |

Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):

|                                  |      |      |      |
|----------------------------------|------|------|------|
| Банкны хувьцаа эзэмшигчид        | 0.0% | 0.8% | 2.4% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.3% | 0.3% | 0.4% |
| Банкны бусад холбогдох этгээд    | 3.8% | 3.2% | 0.1% |

# Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Санжай Гупта  
ТУЗ-ийн дарга



Майкл Мадден  
ТУЗ-ийн гишүүн



Н.Цэлмүүн  
ТУЗ-ийн гишүүн



Б.Уламбаяр  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Нирак Вэдва  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Андрей Витак  
ТУЗ-ийн гишүүн



Г.Цэвэгжав  
ТУЗ-ийн гишүүн



Албертус Браггинк  
ТУЗ-ийн гишүүн



Сюзанна Херринг Карп  
ТУЗ-ийн гишүүн



Эми Чой  
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Доминик Жак  
ТУЗ-ийн гишүүн



Стюарт Холл  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

# Гүйцэтгэх удирдлагын баг



**Г.Цэвэгжав**  
Гүйцэтгэх захирал



**Г.Эрдэнэбаяр**  
Санхүү хариуцсан захирал



**Э.Уламбаяр**  
Иргэдийн банк хариуцсан  
захирал



**Б.Еркин**  
Байгууллагын банк хариуцсан  
захирал



**С.Дауренбек**  
Лизинг хариуцсан захирал



**Илия Аврамов**  
Эрсдэл хариуцсан захирал



**Г.Зул**  
Үйл ажиллагаа хариуцсан  
захирал



**Х.Өнөрбат**  
Мэдээллийн технологи  
хариуцсан захирал



**Н.Мөнхцэлмэг**  
Хууль хариуцсан захирал / ТУЗ-  
ийн нарийн бичгийн дарга



**Э.Ундармаа**  
Ерөнхий аудитор

# Төлөөлөн удирдах зөвлөлийн болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

| 2024 оны жилийн эцэс



## Шинээр баталсан

- Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын 2023-2025 оны шилжилтийн төлөвлөгөө
- Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам
- ТУЗ-ийн 2024 оны сургалтын хөтөлбөр
- ТУЗ-ийн үнэлгээний дараах 2024 оны ажлын төлөвлөгөө
- Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлтгэх бодлого



## Нэмэлт өөрчлөлт оруулсан

- Дотоод мэдээлэл эзэмшигчдийн арилжааны ерөнхий журам

## Нэмэлт өөрчлөлт оруулсан

- Ногдол ашгийн бодлого
- ТУЗ-ийн үнэлгээний журам
- Ажилтны урт хугацаат хуримтлалын хөтөлбөрийн ерөнхий журам
- ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм болон Дотоод аудитын баримт бичиг



📞 (976)-75771888-(888)

✉ InvestorRelation@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>